



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 537

Улаанбаатар хот

“Тулга риэл истэйт” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тулга риэл истэйт” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Тулга риэл истэйт” ХХК (Д.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН